

# “ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 28-ны өдөр

№01

Улаанбаатар хот

## Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн саналын эрхтэй 551485 ширхэг хувьцааны эзэмшигчид буюу нийт хувьцааны 89,73 %-ийг эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР

# “ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 28-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

## Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.9 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ: “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс “2024 онд төлөвлөгөөний дагуу үр дүнтэй ажилласан” гэсэн дүгнэлтийг Хавсралт-1 ёсоор баталсугай.

ХОЁР: “Дархан гурил тэжээл” ХК-ийн өнөөдрийг хүртэл бий болгосон орчин үеийн техник, технологи бүхий үйлдвэрлэлийн нөөц боломж, үл хөдлөх хөрөнгө, газар, инженерийн дэд бүтцийг түшиглэн тус компанийн үйл ажиллагааг идэвхжүүлэн өргөжүүлэх оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР

# “ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 28-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

## Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.9 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2025 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ: “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг баталсугай.

ХОЁР: “Дархан гурил тэжээл” ХК нь 2024 онд зардлаа нөхөж чадаагүй, алдагдалтай байгаа болон Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.2 дугаар заалтад заасан нөхцөлүүдийг хангахгүй байгаа тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР

# “ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04-р сарын 28-ны өдөр

№04

Улаанбаатар хот

## Компанийн эзэмшил газрын кадастрын зургийг шинэчлэх тухай

Монгол улсын Компанийн тухай хууль болон “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн холбогдох заалтуудыг тус тус удирдлага болгон хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 4 сарын 28-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн Засаг дарга болон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас ирүүлсэн албан тоотын дагуу компанийн эзэмшлийн газрын талбайн хэмжээнд өөрчлөлт оруулахгүйгээр 378 м.кв газрыг чөлөөлөх, нөхөн нэмж авах, холбогдох өөрчлөлтийг тусгасан кадастрын зураг гаргуулах ажлыг гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
2. Компанийн эзэмшил газрын талбайн хашааг буулгах, буцаан бариулах ажилд хяналт тавьж ажиллахыг гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
3. Авто замын трассад орсон хашааг буулгах, буцаан барих хугацаанд компанийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд онцгой анхаарал тавьж, автозамын барилгын ажлын төсөвт өртөгт зохих хууль журмын дагуу тусгагдсан түр барилгын ажлын хүрээнд гүйцэтгэгч байгууллагаар түр хашааг бариулан компанийн хэвийн үйл ажиллагааг хангуулан ажиллахыг гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
4. Компанийн газар, хашааг хэвийн байдалд оруулж хүлээлцэх асуудлыг зохицуулсан гэрээг гүйцэтгэгч байгууллагатай байгуулсны үндсэн дээр түр барилгыг барих, зам, барилгын ажлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын хяналт дор эхлүүлэхийг гүйцэтгэх удирдлагад даалгасугай.
5. Шинэчилсэн кадастрын зураг гаргуулах ажлын явцыг Төлөөлөн удирдах зөвлөлд тухай бүр танилцуулахыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР